



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

МОНГОЛБАНК, ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2020 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү хамтын ажиллагааны санамж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг нэг талаас Монголбанк (цаашид “МБ” гэх), нөгөө талаас Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар (цаашид “ГБХЗХГ” гэх) дор дурдсан асуудлаар харилцан тохиролцон үйлдэв.
- 1.2 Хамтын ажиллагааны санамж бичгийн зорилго нь МБ, ГБХЗХГ (цаашид “талууд” гэх) Төв банкны тухай хуулийн 1.5.1.7-д зааснаар “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”; Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20.5.1.-д “залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, 4.1.8.-д “ амьдрах ухааны чадвар” гэж гэр бүл төлөвлөлт, санхүүгийн мэдлэг болон эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах зан үйл, дадал төлөвшилт, нийгэм сэтгэлзүйн чадварыг хэлнэ”, Залуучууд хөгжлийн төвийн дүрмийн 4.1, 5.5.1, 5.5.4 болон Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд залуусын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийх мэдлэг, чадварыг дэмжихэд чиглэгдсэн үйл ажиллагаанд хамтран оролцох, хамтын ажиллагааны зарчим, зохицуулалтын үйл ажиллагааны хүрээг нэгтгэн чиглүүлэхэд оршино.
- 1.3 Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан Төв банкны /Монголбанк/-ны тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Залуучууд хөгжлийн төвийн дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгоно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

Олон нийт, залуучуудын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг дэмжих талаар хамтын ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.

- 2.1 “Гэр бүлийн болон хувь хүний санхүү”-гийн боловсрол олгох амьдрах ухааны хөтөлбөрийг хамтран боловсруулах;

Г.Э

Монголбанк, Гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн газрын хамтын
ажиллагааны санамж бичиг

М.Э

2020 оны 9 дүгээр сар

- 2.2 Хөтөлбөрийг Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан хүргэж буй амьдрах ухааны сургалтын модулийн нэг хэсэг болгон хэрэгжүүлэх;
- 2.3 Санхүүгийн боловсрол олгох сургагч багш нарыг бэлтгэх, тэднийг чадваржуулах;
- 2.4 Хамтарсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 2.5 Талууд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг тус тусын цахим хуудсанд байршуулж, тогтмол шинэчилж байх;
- 2.6 Санхүүгийн мэдлэг олгох гарын авлага, багшийн ном, сургалт явуулахад ашиглагдах материал, видео хичээл болон бусад цаг үеийн хэрэглэгдэхүүнээр хангах;
- 2.7 Санхүүгийн боловсролын чиглэлээр туршлага судлах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 3.1 Талууд энэхүү санамж бичигт заасан үүргийг биелүүлж, бүрэн хариуцлага хүлээн ажиллана.
- 3.2 Талууд энэхүү санамж бичгээр харилцан тохиролцоогүй болон нарийвчилсан ажилд хамтран ажиллах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулж болно.
- 3.3 Хамтран гүйцэтгэх ажил үүргийг талууд тухайн тохиолдолд нарийвчлан тохиролцох бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд талуудын хоорондын харилцаанд энэхүү санамж бичгийг баримтална.
- 3.4 Энэхүү санамж бичгийн хугацаа дуусахад түүнийг сунгах буюу дахин шинээр байгуулж болно.
- 3.5 Энэхүү санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд санамж бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд гурван жилийн хугацаанд хүчинтэй байна.

2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр монгол хэлээр хоёр хувь үйлдэв.

